# НИЙСЛЭЛИЙН
# НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр Дугаар А/18 Улаанбаатар хот

“Коронавируст халдвар /Ковид-19/-аас
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хүрээнд
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 34 дүгээр өргөтгөсөн шуурхай хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/108 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, цаг үеийн нөхцөл байдал, ажлын ачааллалтай уялдуулан ажилтан, албан хаагчдын ажлын цагт зохицуулалт хийж, хуваарь гарган ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулахыг хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хавсралтын дагуу баталсугай.

3. Төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд гаргаж тайлагнаж ажиллахыг менежерүүдэд, хэрэгжилтэд хяналт тавин тайланг нэгтгэн ажиллахыг дотоод хяналт хариуцсан ажилтан Б.Хэнмэдэх нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг Орлогч дарга /Ч.Однасан, Б.Галмандах/, Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\A tushaal.docx

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/18 дугаар тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ААС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРМЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| **Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:** | | | |
| 1.1 | Дээд шатны байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, удирдлага зохион байгуулалтаар ханган авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах | Тухай бүр | Орлогч дарга нар<br>Хэлтсийн дарга<br>Үйлчилгээний албаны дарга<br>Байр ашиглалтын албаны дарга |
| 1.2 | Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн “Шар түвшин”-нд ажлын байранд хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, 50 хүртэл хувийн дүүргэлттэйгээр ажил, үйлчилгээг явуулах, цахим хэлбэрт шилжүүлэх | Тухай бүр | Орлогч дарга нар<br>Хэлтсийн дарга<br>Үйлчилгээний албаны дарга<br>Байр ашиглалтын албаны дарга |
| 1.3 | Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, ариутгалын бодис хэрэглэлийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, тэдгээрийн хэрэглээнд дотоод хяналт тавих | Тухай бүр | Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга<br>Ерөнхий нягтлан<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 1.4 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 7 хоног бүрээр гаргаж дотоод хяналтыг зохион байгуулан тухай бүр нэгтгэж удирдлагад танилцуулах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| **Хоёр. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | |
| 2.1 | Коронавируст халдварт (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журамтай нийцүүлэн НЗЗ-ны байруудад мөрдөж ажиллах, шаардлагатай заавар, зөвлөмжийг боловсруулж сурталчлан таниулах, хэрэгжилтэд хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.2 | Ажилтан, албан хаагч болон иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг “qr.119.mn” сайтаас зааврын дагуу хэвлэн авч, байгууллагын орох хэсэгт ил харагдахаар байршуулах, халуун хэмжигчийг бэлтгэн байршуулах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Зоогийн газрын менежер |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 2.3 | Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг нийслэлийн засаг захиргааны байруудаар нэвтрүүлэхдээ зөвхөн амны хаалт зүүсэн ажилтан, албан хаагчдын биеийн халууныг хэмжих, "QR кодыг уншуулах, иргэний үнэмлэхийг үндэслэн заавал бүртгэх, заавар зөвлөмж өгч нэвтрүүлэх, ажлыг зохион байгуулалтад оруулах, хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.4 | Ажлын байранд үйлчлүүлэгч болон ажилтны гар угаах нөхцөлийг бүрдүүлж, гарын шингэн саван, цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгч байршуулж үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй ашиглуулах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.5 | Гаднаас нэвтэрч байгаа эд зүйлс , бараа материалыг зохих зааврын дагуу халдваргүйжүүлж нэвтрүүлэх | Тухай бүр | Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.6 | Нийслэлийн засаг захиргааны байруудад ажиллаж буй байрны жижүүр, цагдаа, харуул хамгаалалтын ажилтнуудын өндөржүүлсэн бэлэн байдал ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.7 | Нийслэлийн засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээг халдвар хамгааллын заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэх, дэглэмийг чанд мөрдүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.8 | Байруудын гадна орчны 50 метр талбайн хог, хаягдал, цас, мөсийг тогтмол цэвэрлэх, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүрэг болон мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, түүнд хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 2.9 | Хурлын танхимын багтаамж, хүчин чадлаас шалтгаалан хуралд оролцогчдын хүн хоорондын зайг 2 метрээс доошгүй, 10 хүнээс илүүгүй байхаар тооцож, зохион байгуулах, хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвших, зөвлөмж өгч ажиллах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Хурлын заалны зохион байгуулагч |
| 2.10 | Халдварын үед хамгаалах хувцас, хэрэгслийг зөв дараалаар өмсөж, тайлах, цар тахлын халдвараас хэрхэн урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, халдвараас сэргийлэх, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зааварчилгаа, зөвлөмж өгөх | Тухай бүр | Их эмч<br>Дотоод ажил, сургалт хариуцсан ажилтан |
| | **Гурав. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх чиглэлээр:** | | |
| 3.1 | Байруудын гадна орчны 50 метр хүртэлх талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд |
| 3.2 | Зоогийн газрын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтэд онцгой анхаарч гаднаас хүлээн авч буй хүнсний түүхий эд, бараа, бүтээгдэхүүний хайрцаг, сав, боодлын гадаргуug сайтар арчиж цэвэрлэх, битүүмжлэлгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг угааж, цэвэрлэсний дараа агуулахад хадгалж | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Зоогийн газрын менежер |

| | | | |
|---|---|---|---|
| | хэрэглэх | | |
| 1 | 2 | 3 | 4 |
| 3.3 | Нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэлийн танхимын ширээ хоорондын зайг 2 метрээс доошгүй ширээнд алгасч суухаар тооцон зохион байгуулах, тэмдэг тэмдэглээ хийх, ширээ бүрт QR кодыг байрлуулж, код уншиж байгаад хяналт тавих | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Зоогийн газрын менежер |
| 3.4 | Хариуцаж буй байруудын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн давтамжийг нэмэгдүүлэх, тогтмол хийх, шаардлагатай үед мэргэжлийн байгууллагатай хамтрах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд |
| 3.5 | Хэрэглэсэн аяга, таваг, хэрэгслийг 3 дамжлагат угаалгаар зааврын дагуу угааж, халдваргүйжүүлсний дараа хэрэглэх | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Зоогийн газрын менежер |
| 3.6 | Үйлчлүүлэгчийн бэлэн мөнгөний төлбөр тооцоог аль болох татгалзах, карт ашиглан тооцоо хийх, “ПОС” машиныг цэвэрлэж, халдваргүйжүүлэх | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Зоогийн газрын менежер |
| 3.7 | Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааг тухай бүр байгууллагын ажилтан, албан хаагчдын нэгдсэн группд байршуулах | Тухай бүр | Байр ашиглалтын албаны дарга<br>Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Зоогийн газрын менежер |
| **Дөрөв. Сэжигтэй тохиолдол илэрвэл авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр** | | | |
| 4.1 | Байруудад халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд байранд нэвтрүүлэх хөдөлгөөнийг зогсоож, түр тусгаарлах өрөөнд тусгаарлаж эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэх | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд<br>Дотоод хяналт хариуцсан ажилтан |
| 4.2 | Сэжигтэй тохиолдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллах | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд |
| 4.3 | Ажлын байранд батлагдсан тохиолдол илэрвэл мэргэжлийн байгууллагаар голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийлгэх | Тухай бүр | Үйлчилгээний албаны дарга<br>Байр хариуцсан менежерүүд |